

Маягт СЗХ04008

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	07	Өдөр	06
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Бизнес тасалдлын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Санхүүгийн даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинээр батлах тухай		2021-02-26		ЗТ-21/02-043	
6	Цахимаар борлуулах эсэх	Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах						
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>							
9	Даатгалын зүйл	Бизнесийн үйл ажиллагаа нь түр тасалдсан хугацаанд гарах тогтмол зардал					
	Даатгалын үндсэн эрсдэл	Галын эрсдэл Байгалийн эрсдэл Цахилгааны эрсдэл Сантехникийн эрсдэл Гуравдагч этгээдийн эрсдэл					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.07%-1.33%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

## ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Даатгагдсан эд хөрөнгийн үйлчилгээ, урсгал засвартай холбоотой гарсан сул зогсолтоос шалтгаалан алдсан орлого;
2. Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгуулагч, түүний ажилтны санаатай үйлдсэн үйлдэл, эс үйлдэхүй болон гэмт хэрэг, зөрчлийн шинж чанар, зорилготойгоор үйлдсэн үйлдлийн улмаас учруулсан аливаа хохирол;
3. Даатгагч нь эд хөрөнгийн даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр олгохоос татгалзсан шийдвэр гарсан тохиолдолд Бизнес тасалдлын даатгалын хамгаалалт үйлчлэхгүй.
4. Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын тохиолдлоос үүдэн олж чадаагүй ашиг, орлого;
5. Даатгуулагч даатгагчид мэдэгдэлгүй хохирлыг дур мэдэн барагдуулж хохирлын бодит үнэлгээг тогтоох, батлах боломжгүй болгосон тохиолдолд;
6. Даатгуулагч болон түүний ажилтан нь хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэвэл зохих хугацаандаа дур мэдэн өөр ажил гүйцэтгэсэн, ажлын байраа орхиж явсан, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, сэтгэл санааны хямрал, сэтгэцийн эмгэг, эрх зүйн чадамжгүй үедээ эсхүл түр зуурын шокийн байдалтай байх үедээ учруулсан болон хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны горимыг илтэд, санаатай зөрчсөний улмаас учирсан хохирол;
7. Даатгуулагчийн эрхэлж буй үйл ажиллагаа нь Монгол улсын зохих лиценз зөвшөөрөлгүй байхад тохиолдсон бусдын амь нас, эрүүл мэнд, хөрөнгөд хохирол учирсны төлөө хүлээх хариуцлага болон бусдын жор, патент, лиценз, гэрчилгээний эрхийг зөрчсөнөөс үүссэн хохирол;
8. Ажил хаялтаас үүдсэн болон, эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагааг нь түр зогсоосон, хязгаарлалт тогтоосноос үүссэн хохирол;
9. Даатгуулагч даатгалын хураамжийг гэрээнд заасан нөхцөл, хугацаа, хэмжээгээр төлөөгүй байх үед учирсан хохирол;
10. Даатгалын гэрээ байгуулагдахаас өмнө бий болсон эрсдэл, хохирол;
11. Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас оногдуулсан мөнгөн торгууль, шийтгэвэр;
12. Хууль тогтоомжид заасан бусад.